

БАТЛАВ.
"ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г. ТӨМӨРБААТАР

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ БАЙГУУЛЛАГДСАНЫ 380 ЖИЛИЙН ОЙ,
НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙГ УГТСАН
“НИЙТИЙН ТЭЭВРИЙН СОЁЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ”
СЭДЭВТ АЯНЫ УДИРДАМЖ

1. ЗОРИЛГО:

Нийслэл хотын 380 жилийн ой, Нийслэлийн тээврийн газар байгуулагдсаны 50 жилийн ойг угтан нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг соёлч боловсон хүргэх, ажилчдын идэвхи санаачлагыг өрнүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцох, осол зөрчлийг бууруулах, Замын хөдөлгөөний дүрэм, нийтийн тээврийн стандартуудыг мөрдөх, үйлчилгээний соёлыг дээшлүүлж ажиллахад аяны зорилго оршино.

2. ХАМРАГДАХ ХҮРЭЭ:

1. Бүх хэлтэс, алба
2. "Зорчигч тээврийн нэгтгэл" -ийн 1 дүгээр бааз
3. "Зорчигч тээврийн нэгтгэл" -ийн 2 дугаар бааз

3. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

“Нийтийн тээврийн соёлтой үйлчилгээ” аян нь нэг сарын хугацаанд үргэлжлэх бөгөөд аяныг байгууллагын цахим хуудас мэдээлэлийн самбар, ажилчдын хурал зөвөлгөөнөөр сурталчилан таниулж бүх ажилтан, албан хаагчдыг хамруулна.

Нэг сарын аяныг дүгнэхдээ гэнэтийн болон байнгын шугамын шалгалтын мэдээ тайлан болон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны үр дүнг харгалзан аянд идэвхитэй, бусдыгаа манлайланоролцсон хэсэг болон ажилтануудыг дараах үзүүлэлтээр шалгаруулж манлайлагч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

1. МАНЛАЙЛАГЧ ХЭСЭГ, ХАМТ ОЛОН -1

1. Шугам цагийн гүйцэтгэл
2. Өглөөний гаралт, оройн гаралт, ээлж солилтын биелэлт
3. Ашиглалтын саатал / тээвэр зохицуулалт сайн зохион байгуулж ашиглалтын саатал гаргаагүй байх /
4. Үйлчилгээний санал гомдлын тоог бууруулсан байдал
5. Зам тээврийн ослын тоог бууруулсан байдал
6. Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс ирсэн зөрчлийн торгууль
7. Шугам замд саад учруулсан тээврийн хэрэгслийн тоо

8. Нийтийн тээврийн стандартын мөрдөж /хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гарны оролцоотой утсаар ярих, зорчигчийн танхимд дуу хөгжим чанга тавих, буудал зогсоолд бүрэн гүйцэд орж зогсох, нэрийн хуудас, гаралтын дугаар, ажлын хувцас өмсөх г.м./
9. Автобусны өнгө үзэмж сайжруулах /гадна дотор цэвэрлэгээ, заал, суудлын бүрээсний угаалга г.м./

2. МАНЛАЙЛАГЧ ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАГЧ /ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР /-1

Үндсэн шалгуур үзүүлэлт

1. Шугам цагийн гүйцэтгэл
2. Өглөөний гаралт, оройн гаралтын биелэлт
3. Ашиглалтын сааталгүй ажиллах
4. Замын хуудасны их бүрэн байдал, замын хуудасны тооцоолол хаасан байдал, рейс тоололт, шатахуун зарцуулалтын цохолт, хяналт

Туслах шалгуур үзүүлэлт

1. Тухайн ээлжиндээ нийтийн тээврийн стандартын хэрэгжилтийг хангаж ажилласан байх / нэрийн хуудас, гаралтын дугаар, чиглэлийн хаяг, ажлын хувцаслалт, гадна дотор угаалга цэвэрлэгээ гэх мэт/

3. МАНЛАЙЛАГЧ ЖОЛООЧ-60 /автобусны төрөл тус бүрээр/

1. Ажлын үзүүлэлт /шугам цаг, ээлжтэй ажилласан/
2. Ухаалаг нийтийн тээврийн ТВОХ системд бүртгэгдсэн ямар нэгэн зөрчилгүй байх /буудалд зогсоогүй, маршрутын зөрчил, гаралтын дараалал гэх мэт/
3. Тушаалаар арга хэмжээ тооцогдоогүй байх
4. Үйлчилгээний санал гомдол гаргаагүй байх
5. Зам тээврийн осолд холбогдоогүй байх
6. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргаагүй байх
7. Нийтийн тээврийн стандартын мөрдөж /хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гарны оролцоотой утсаар ярих, зорчигчийн танхимд дуу хөгжим чанга тавих, буудал зогсоолд бүрэн гүйцэд орж зогсох, нэрийн хуудас, гаралтын дугаар, зорчигчдод зориулсан санамж, ажлын хувцас өмсөх г.м./
8. Автобусны өнгө үзэмж сайжруулах /гадна дотор цэвэрлэгээ, заал, суудлын бүрээсний угаалга г.м./

4. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЫН ИНЖЕНЕР-1

1. Ажлын үзүүлэлт, автобусыг шуурхай засварлах ажлыг оновчтой зохион байгуулах
2. Техникийн бэлэн байдлыг 90 %-иас доошгүй хангаж, стандарт мөрдүүлж ажиллах
3. Техникийн сааталтай цаг гаргаагүй байх
4. Замд эвдэрсэн тээврийн хэрэгслийн зөрчил гаргаагүй байх
5. Засварын сааталгүй, жолооч нараас санал гомдолгүй ажиллах
6. Үзлэг оношилгоонд бэлдэх ,тээврийн хэрэгслийн бэлэн байдал хангах

5. МАНЛАЙЛАГЧ ШАЛГАХМЕХАНИК-1

1. Ажлын үзүүлэлт
2. Шугаманд гарах, шугамнаас орж ирсэн тээврийн хэрэгсэлд шалгалт хийж, техникийн бэлэн байдал хангуулж, стандарт мөрдүүлэлтэд хяналт тавих
3. Техникийн хувьд бүрэн бус стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийг ажилд гаргахгүй байх
4. Шалгах хуудасны бөглөлт зөрчилгүй байх, хэвийн бс жолооч ажилд гаргахгүй байх

6. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЧИН-1

1. ХОК-ийн үзүүлэлтээр тэргүүлсэн байх
2. Цаг ашиглалт ажлын байрны зохион байгууллалтыг оновчтой болгосон
3. Засвар үйлчилгээний ажлын чанар, тоног төхөөрөмжтэй горимын дагуу ажиллах
4. ХХАА-ны зөрчилгүй ажиллах

7. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЫН МАНААЧ-ТЭРЭГ ТАВИГЧ, УГААЛГЫН ОПЕРАТОР-1

1. Ажлын үзүүлэлт
2. Өмч хөрөнгө, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчилгүй байх
3. Хариуцсан талбайг өдөр бүр цэвэрлэх, цэвэр байлгах, хогийг тухай бүр зайлуулах Жич. Жижүүр, манаач,механикч-тэрэг тавигч нар өөр дээрээ тавигдах ёстой түлхүүрийг бүрэн хүлээн авсан байх, мөн хариуцсан байр талбайд гадны машин тавиулаагүй байх
4. Байнга ажлын байран дээрээ байж бичиг баримтгүй, согтуу хүмүүсийг хариуцсан талбайд нэвтрүүлээгүй байх

8. МАНЛАЙЛАГЧ ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН-1

1. Цаг ашиглалт болон ирц бүрэн / цаг ашиглалт ажлын бүтээмжийг харгалзан үзнэ/
2. Ажлын байрны дүгнэлт, үүрэг даалгаврын биелэлт 100%
3. Ажлын багаж, хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл бүрэн, аюулгүй ажиллагааны болон сахилгын зөрчилгүй байх
4. Идэвхи санаачлага, бүтээлч санаа түүний хэрэгжилт бүрийг харгалзан үзэх
5. 5S-ийн зарчмын хэрэгжүүлэлт, хэвшилтийг харгалзан үзэх/ ажлын хувцасыг тогтмол цэвэр цэмцгэр өмсөх, ажлын байр талбайг тогтмол цэвэрлэх, ажлын багаж хэрэгсэлийг эмх цэгцтэй байлгах г.м /

9. МАНЛАЙЛАГЧ ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ЗАСВАРЧИН, ЦАХИЛГААНЧИН-1

1. Цаг ашиглалт болон ирц бүрэн / цаг ашиглалт ажлын бүтээмжийг харгалзан үзнэ/
2. Ажлын байрны дүгнэлт, үүрэг даалгаврын биелэлт 100%

3. Ажлын багаж, хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл бүрэн, аюулгүй ажиллагааны болон сахилгын зөрчилгүй байх
4. Идэвхи санаачлага, бүтээлч санаа түүний хэрэгжилт бүрийг харгалзан үзэх
5. 5S-ийн зарчмын хэрэгжүүлэлт, хэвшилтийг харгалзан үзэх/ ажлын хувцасыг тогтмол цэвэр цэмцгэр өмсөх, ажлын байр талбайг тогтмол цэвэрлэх, ажлын багаж хэрэгсэлийг эмх цэгцтэй байлгах г.м /

10. ШИЛДЭГ ШИНЭ САНАА / ШБОС /-1

Байгууллагын үр ашгийг дээшлүүлэх, зардал хэмнэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хөдөлмөр хөнгөвчилсөн шинэ санаа, оновчтой бүтээл /г.м./

11. Аянд санаачлагатай оролцсон захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн ажилтан-1

12. Аянд санаачлагатай оролцсон санхүү, бүртгэлийн хэлтсийн ажилтан-1

13. Аянд санаачлагатай оролцсон дотоод хяналт, шалгалтын хэлтсийн ажилтан-1

4. **УРАЛДААНЫ ХУГАЦАА:** 2019.02.23-наас 2019.03.22-нийг дуустал

5. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ:

2019 оны 04 дүгээрсарын 01-ны өдөр ЗТН-ийн захиралын дэргэдэх зөвлөлийн хурлаар дүгнэнэ.

6. ШАГНАЛ

Нийт шагналын сан 10 000 000 /арван сая/ төгрөг

1. Манлайлагч хэсэг, хамт олон-1	500,000 төгрөг
2. Манлайлагч ээлжийн инженер-1	200,000 төгрөг
3. Манлайлагч жолооч	
a. Дэү БС-106 автобусны жолооч-10 /тус бүр/	200,000 төгрөг
b. Угсраа автобусны жолооч-2 /тус бүр/	200,000 төгрөг
c. Троллейбусны жолооч-3 /тус бүр/	200,000 төгрөг
a. Дэү БС-106 автобусны жолооч-40 /тус бүр/	100,000 төгрөг
b. Угсраа автобусны жолооч-2 /тус бүр/	100,000 төгрөг
c. Троллейбусны жолооч-3	100,000 төгрөг
4. Манлайлагч засварын инженер-1	200,000 төгрөг
5. Манлайлагч шалгах механик-1	100,000 төгрөг
6. Манлайлагч засварчин-1	100,000 төгрөг
7. Манлайлагч тэрэг тавигч, манаач-1	100,000 төгрөг
8. Цахилгаан хангамжийн албаны ажилтан-1	100,000 төгрөг
9. Цахилгаан хангамжийн засварчин, цахилгаанчин-1	100,000 төгрөг
10. Шилдэг шинэ санаа, ШБОС-1	200,000 төгрөг
11. Манлайлагч хүний нөөцийн ажилтан-1	100,000 төгрөг
12. Манлайлагч санхүү, бүртгэлийн ажилтан-1	100,000 төгрөг
13. Манлайлагч дотоод хяналт, шалгалтын ажилтан-1	100,000 төгрөг
14. Бусад зардал / өргөмжлөл/	600,000 төгрөг

Зохион байгуулагч: ЗТН-ийн захиргаа

НИЙСЛЭЛИЙН УЛААНБААТАР ХОТ БАЙГУУЛАГДСАНЫ 308 ЖИЛИЙН ОЙ,
НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙГ УГТСАН
“НИЙТИЙН ТЭЭВРИЙН СОЁЛТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ” СЭДЭВТ АЯНЫ УДИРДАМЖИЙН ДАГУУ
ШАЛГАРУУЛАЛТ ХИЙСЭН ДҮН

1. МАНЛАЙЛАГЧ ХЭСЭГ, ХАМТ ОЛОН-1

Тус нэгтгэлийн 2 баазын хэмжээнд нийт 7 хэсэг шалгаруулалтад орсон. 1 дүгээр баазаас 4 хэсэг, 2 дугаар баазаас 3 хэсэг оролцсон болно. Үүнээс:

Шалгарсан хэсэг 1 ДҮГЭЭР БААЗЫН ХҮРЭЛБААТАР ДАРГАТАЙ 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

2. МАНЛАЙЛАГЧ ТЭЭВЭР ЗОХИЦУУЛАГЧ / ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР /-1

2 баазын нийт 8 ээлжийн инженер шалгаруулалтад орсон. Үүнээс:

Шалгарсан инженер 1 ДҮГЭЭР БААЗЫН ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР Б.БАТБАЯР

3. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЫН ИНЖЕНЕР -1

Шалгаруулалтад 1 дүгээр баазаас засварын инженер Г.Баярмөнх, 2 дугаар баазаас засварын инженер Т.Энхсаруул нарын материал ирж оролцсон. Үүнээс:

**Шалгарсан засварын инженер: 1 ДҮГЭЭР БААЗЫН ЗАСВАРЫН ИНЖЕНЕР
Г.БАЯРМӨНХ**

4. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЧИН -1

Шалгаруулалтад 1 дүгээр баазаас засварчин О.Цолмон, 2 дугаар баазаас засварчин Ц.Ганбат нарын материал ирж оролцсон. Үүнээс:

Шалгарсан засварчин: 2 ДУГААР БААЗЫН ЗАСВАРЧИН Ц.ГАНБАТ

5. МАНЛАЙЛАГЧ ШАЛГАХ МЕХАНИК -1

Шалгаруулалтад 1 дүгээр баазаас шалгах механик А.Даваасүрэн, 2 дугаар баазаас шалгах механик Г.Чинзориг нарын материал ирж оролцсон. Үүнээс:

Шалгарсан засварчин: 1 ДҮГЭЭР БААЗЫН ШАЛГАХ МЕХАНИК А.ДАВААСҮРЭН

6. МАНЛАЙЛАГЧ ЗАСВАРЫН МАНААЧ-ТЭРЭГ ТАВИГЧ, УГААЛГЫН ОПЕРАТОР-1

Шалгаруулалтад 1 дүгээр баазаас тэрэг тавигч Д.Наянжин, 2 дугаар баазаас тэрэг тавигч С.Цогтбаатар нарын материал ирж оролцсон. Үүнээс:

Шалгарсан шалгах механик: 1 ДҮГЭЭР БААЗЫН ТЭРЭГ ТАВИГЧ Д.НАЯНЖИН

7. МАНЛАЙЛАГЧ ЖОЛООЧ-60

/ нэрсийг хавсралтаар/

8. МАНЛАЙЛАГЧ ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН АЖИЛТАН-1

Шалгарсан: **2 ДУГААР БААЗЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ИНЖЕНЕР
Б.АШИМ**

9. МАНЛАЙЛАГЧ ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ЗАСВАРЧИН,
ЦАХИЛГААНЧИН-1

Шалгарсан :**2 ДУГААР БААЗЫН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН АЛБАНЫ ЗАСВАРЧИН,
ЦАХИЛГААНЧИН Н.ЭРДЭНЭБУЛГАН**

10. ШИЛДЭГ ШИНЭ САНАА /ШБОС/

Шалгаруулалтад:**1 ДҮГЭЭР БААЗЫН ЗАСВАРЧИН Ш.БАТСУУРИЙН ШИЛДЭГ САНАА
НЭР: АВТОБУСНЫ БАРБАНЫ ДОТОР ДИАМЕТРИЙГ ХЭМЖИГЧ**

2 ДУГААР БААЗЫН ЗАСВАРЧИН О.АЛТАНБАЯРЫН ШИЛДЭГ САНАА

НЭР: КОНСНЫ АППАРАТНЫ ХИЙ АВАГЧбүтээлүүдээр оролцсон. Үүнээс:

Шалгарсан:**2 ДУГААР БААЗЫН ЗАСВАРЧИН О.АЛТАНБАЯРЫН ШИЛДЭГ САНАА**

НЭР: КОНСНЫ АППАРАТНЫ ХИЙ АВАГЧ

11. АЯНД САНААЧЛАГАТАЙ ОРОЛЦСОН:

Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс: **1 ДҮГЭЭР БААЗЫН ХНА-НЫ АХЛАХ
МЕНЕЖЕР Б.ДУЛАМСҮРЭН**

Санхүү бүртгэлийн хэлтэс :**Ч.ЦЭЦЭГЭЭ**

Дотоод хяналт, шалгалтын хэлтэс: **Б. БАТЧИМЭГ**

Хавсралтаар жолооч нарын нэрс:

ТЭРГҮҮНИЙ МАНЛАЙЛАГЧ ЖОЛООЧ - 15

№	Ёйă	НЭРС	ХОНОГ	НИЙТЦАГ	ТӨЛӨВ	ШУГАМЦАГ	Хувь
1	111018	ОтгонжаргалЦоодолийн	28	218	127	186	146.46%
2	114077	Ган-ЭрдэнэЗундуйдоржийн	25	193	126	180	142.86%
3	113022	ДамдинсүрэнЧулуунбаатарийн	27	200	127	179	140.94%
4	111103	ГанцоожДашдондогийн	28	210	127	179	140.94%
5	112033	ЭрдэнэсүхБаярсайханий	27	216	126	175	138.89%
6	111041	ÀìàðààüðМагсаржавийн	27	202	127	175	137.80%
7	114087	ЦогооЦэрэннадмидийн	25	200	126	173	137.30%
8	114026	БатчулуунСанжсүрэнгийн	29	202	126	172	136.51%
9	114001	БатбаярШинэзууний	24	196	126	172	136.51%
10	111047	БатжаргалМягмарсүрэнгийн	26	186	127	173	136.22%
11	123052	ĀāíāīēāĀ¿āyðñ¿ðyíāēēí	204	28	180	125	144.00%
12	123030	Äyēāyðāāēāēíðēííēēēēí	195	24	177	125	141.60%
13	121001	ÝðāyíyāāðĀyēāyðāāēāēāēēí	203	28	184	126	146.03%
14	121044	Íyðā¿éĀyíāyðyēēēí	192	24	170	126	134.92%
15	121002	ĀāāāāāēāāĀīīāīāīðāēēēí	181	25	165	126	130.95%

МАНЛАЙЛАГЧ ЖОЛООЧ-45							
№	Ёйă	НЭРС	ХОНОГ	НИЙТЦАГ	ТӨЛӨВ	ШУГАМЦАГ	Хувь
1	131071	ХандсүрэнСампилын	25	185	125	170	136.00%
2	132087	ДоржжанцанТаравын	27	192	125	167	133.60%
3	132031	ГантулгаШархүү	25	197	126	168	133.33%
4	111006	ЭрдэнэцогтМаамийн	25	196	127	167	131.50%
5	133014	БаттулгаЧулуунбатын	25	190	126	165	130.95%
6	132026	ГанболдБаасанжав	24	197	127	166	130.71%
7	112043	БаярсайханЖамбалхоролийн	26	183	127	166	130.71%
8	112011	ĀāyðñāēēōāīДарьсүрэнгийн	25	182	126	164	130.16%
9	132040	ДашдоржБаттулгын	27	201	126	164	130.16%
10	133102	ДаваанямБатмөнх	25	183	127	165	129.92%
11	113098	РэнчиндоржДашдоржийн	27	185	127	165	129.92%
12	112072	СүхбаатарБаттогтохийн	25	189	127	165	129.92%
13	131036	БаасанжавБорхүү	26	196	124	161	129.84%
14	112032	БиндэръяаЯдамийн	25	179	126	163	129.37%
15	133107	Āāð-Āīāāēāí×ōēōóíāāðūí	27	200	126	163	129.37%
16	132057	ДаваадашДаваадорж	24	179	126	162	128.57%
17	113086	ГандешБуянжаргалийн	22	189	127	163	128.35%
18	114070	ОдсүхСүхээгийн	26	188	127	163	128.35%
19	132083	ДаваадоржЦагаанхүү	23	182	125	160	128.00%
20	114024	ЭнхжаргалДагвадоржийн	25	181	126	161	127.78%

21	113097	МөнхбаярЭрдэнэбатын	27	196	127	162	127.56%
22	113078	СайнтогтохБадамгаравийн	26	190	122	155	127.05%
23	112085	ЭнэрэлЭнхтайваний	23	184	126	160	126.98%
24	112064	ТүвдэнгаравБуяндалайгийн	25	188	126	160	126.98%
25	111033	АлтанхуягАлтангэрэлийн	25	181	126	160	126.98%
26	112048	ГантулгаОюунбаатарын	27	184	127	161	126.77%
27	114053	ЭнхжаргалДамдинжавын	24	171	126	159	126.19%
28	112052	ÌàéààÿðДоржмаагийн	26	202	126	159	126.19%
29	114084	ШинэзагдЧагнаадоржийн	24	174	127	160	125.98%
30	114101	ХосбаярЛхагважавийн	25	186	127	160	125.98%
31	112071	ДалайцэрэнСэргэлэнгийн	26	189	127	160	125.98%
32	112010	ЦогтбаатарБатбаярын	26	177	127	160	125.98%
33	111005	УранбатБямбасүрэнгийн	25	183	127	160	125.98%
34	133033	БулганбаатарИванов	25	187	125	157	125.60%
35	133105	ÝðäÿíÿààðÑàíàìààäëéí	25	180	125	157	125.60%
36	112000	АрсланбаатарЦэрэндоржийн	25	198	126	158	125.40%
37	133064	ГанболдДашдондог	24	178	126	158	125.40%
38	112073	БаттүвшинБямбасүрэнгийн	25	176	127	159	125.20%
39	113037	ЦэрэнбадамЭрдэнэцэцэгийн	25	180	128	160	125.00%
40	133119	БаасанжавСодномцогийн	25	180	126	157	124.60%
41	123043	ЖамсранЛантуугийн	192	25	170	126	134.92%
42	123011	ÝäóàðäàÝðäÿíÿóðíàòóíí	189	26	168	125	134.40%
43	121008	ÁàòíàíííÒààäàéí	180	26	163	126	129.37%
44	121078	ÓðàíæàðäàäëÄííàíòóíí	180	26	163	125	130.40%
45	121040	Áàò-íí-èðÁàíçðàä-ëéí	182	27	162	126	128.57%

“Нийтийн тээврийн соёлтой үйлчилгээ” сэдэвт аяны өргөмжлөлийн үг

1. МАНЛАЙЛАГЧ ХЭСЭГ, ХАМТ ОЛОН-1

Эрхэм хүндэт **Ч.ХҮРЭЛБААТАР** даргатай
1 дүгээр хэсгийн хамт олонд

Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 380 жилийн ой, Нийслэлийн тээврийн газар байгуулагдсаны 50 жилийн ойг угтсан “Нийтийн тээврийн соёлтой үйлчилгээ” сэдэвт аяны хүрээнд идэвх санаачлагатай ажиллаж **“МАНЛАЙЛАГЧ ХЭСЭГ, ХАМТ ОЛОН”**-оор шалгарсан тул өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.

ЗАХИРАЛ

Г.ТӨМӨРБААТАР

Улаанбаатар хот

2019 он







